

Д вирус хепатит гэж юу вэ?

Д вирус хепатит нь хепатитийн Д вирус (ХДВ)-ээр үүсгэгддэг халдварт өвчин бөгөөд вирус хепатитийн бусад хэлбэрүүдээс хамгийн хүндээр элгийг гэмтээдэг юм. Зөвхөн В вирус хепатиттай өвчтөнүүдэд ХДВ халдварлах боломжтой бөгөөд В вирус хепатиттай 20 өвчтөн тутмын 1 нь ХДВ-ийн хавсарсан халдвартай байна.

Яагаад би хепатитийн В вирус (ХВВ)-ийн халдвартай өвчтөнийг ХДВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулах ёстой вэ?

Зөвхөн ХВВ-ийн халдвартай өвчтөнүүдтэй харьцуулахад ХДВ-ийн халдвар хавсрах нь элэгний хатуурал болон элэгний хавдар үүсэх явцыг хурдасгана. Хепатитийн В, Д вирусийн хавсарсан халдвартай өвчтөнүүдийг хянах, эмчлэх заавар нь дан ХВВ-ийн халдвартай өвчтөнүүдийнхээс ялгаатай байдаг.

ХВВ-ийн халдвартай дараах хүмүүсийг ХДВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулаарай:

- Африк, Зүүн Европ, Ойрхи Дорнод, Монгол, Пакистан болон Төв Азиас гаралтай өвчтөнүүд
- В вирус хепатитийн эмийн эмчилгээнд хамрагдсан ч эмчилгээ үр дүнгүй эсвэл элэгний үйл ажиллагааны үзүүлэлтүүд ихэссэн өвчтөнүүд
- Элэгний хатууралтай өвчтөнүүд



ХВВ-ийн халдвартай өвчтөнүүдээ хэрхэн шинжилгээнд хамруулах вэ?

Хепатитийн В, Д вирусийн хавсарсан халдварыг оношлох эхний алхам бол ХДВ-ийн эсрэг бие (anti- HDV) илрүүлэх шинжилгээ юм. Хэрвээ шинжилгээний хариу эерэг гарвал ХДВ-ийн нуклейн хүчлийг тодорхойлох шинжилгээ хийж оношийг баталгаажуулна.

Шинжилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг :

[Centers for Disease Control and Prevention \(CDC\), ARUP Laboratories, Quest Diagnostics.](#)

ХВВ/ХДВ-ийн хавсарсан халдвартай өвчтөнүүдийг хэрхэн хянах вэ?

Одоогоор пег-интерферон нь ХДВ-ийг дарангуйлах, элэгний гэмтлээс сэргийлэх үндсэн эмчилгээ болж байна. Өвчтөнүүд 6 сар тутам элэгний гэмтэл болон элэгний хавдрыг илрүүлэх шинжилгээ хийлгэх шаардлагатайгаас гадна архи, тамхи, согтууруулах ундаа, элгэнд нөлөөлөх эмийн болон химийн бодисын зохисгүй хэрэглээнээс зайлсхийх, эрүүл амьдралын хэв маягийг эрхэмлэх нь чухал. Өвчтөний гэр бүлийн гишүүд болон бэлгийн хамтрагчийг шинжилгээнд хамруулах хэрэгтэй.